

Батлав. Засаг дарга

Д.Нэргүй



Увс аймаг Зүүнговь сум

Ерөнхий боловсролын сургууль

Огноо: 2020.01.17

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ ХҮҮХДИЙН ХООЛНЫ
ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Ерөнхий боловсролын сургуулийн Дотуур байрны хүүхдийн хоол хүнсний
материал

Төслийн дугаар: УВАЗГСЗДТГ/202001010

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: ЕБС-д дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: УВАЗГСЗДТГ202001010

Увс аймаг Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Ерөнхий боловсролын сургуулийн Дотуур байрны хүүхдийн хоолны жимс жимсгэнэ, мах махан бүтээгдэхүүнийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Цахим тендер зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50000 төгрөгийг Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн 100150555408 дансанд төлнө.

Багцийн дугаар - Багцийн нэр - Тендерийн баталгаа

БАГЦ1: МАХНЫ БАГЦ -489034

БАГЦ 2: ЖИМС ЖИМСГЭНИЙ БАГЦ -222860

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020.04.11-ны 10³⁰цагаас өмнө tender.gov.mn хаягаар PDF файлаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020.04.11-ны өдрийн 11⁰⁰цагт нээнэ.

Гадаадын давуу эрх тооцох эсэх- үгүй

Дотоодын давуу эрх тооцох эсэх- үгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Зүүнговь сум 5-р баг

Төсөл төрийн сангийн мэргэжилтэн Г.Чимэд-очир-99417912

Сургуулийн нийгмийн ажилтан Ш.Долгор- 80895960

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

<p>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</p>	<p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p>
<p>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</p>	<p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> <p>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p>
<p>3. Тендерийн иж бүрдэл</p>	<p>3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> (а) Үнийн санал; (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь; (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг; (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
<p>4. Тендерийн үнэ</p>	<p>4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</p>
<p>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</p>	<p>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p> <p>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.</p>
<p>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</p>	<p>6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p>

<p>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</p>	<p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.</p> <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> <p>35.5 Барааг ТӨӨЗ-ны 1.2 дахь хэсэгт хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг багц тус бүрт хийх бөгөөд харин гэрээ байгуулах эрх олгохдоо нэг багц, хэд хэдэн багц, эсхүл бүх багцын аль үр ашигтай хувилбарыг сонгож болно.</p>
<p>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</p>	<p>8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p>

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

<p>ТӨӨЗ-ны холбогдох заалт</p>	<p align="center">Ерөнхий зүйл</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<p>Захиалагч нь: Зүүнговь сум Ерөнхий боловсролын сургууль</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<p>Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Ерөнхий боловсролын сургуулийн Дотуур байрны хүүхдийн хоолны жимс жимсгэнэ, мах махан бүтээгдэхүүнийг нийлүүлэх</p>
<p align="center">Шалгуур үзүүлэлт</p>	
<p>ТӨӨЗ 1.1</p>	<p>1. Тендерт оролцох мэдэгдэл, үнийн санал 2. Сүүлийн хоёр жилийн санхүүгийн тайлан 4. Сүүлийн хоёр жилийн туршлагын мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> • Борлуулалтын хэмжээ: Санал болгож буй багцын үнийн дүнгийн 50%-иас багагүй байна • Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 1 жил • Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: үгүй • Дотоодын бараанд давуу эрх тооцох эсэх: тооцно. <p>5. Бараа бүтээгдэхүүний эрүүл ахуйн шинжилгээний бичиг 6. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар / нотариатаар баталгаажуулсан / 7. Татварын байгууллагын тодорхойлолт 8. Харилцагч банкны тодорхойлолт 9. Тендерийн бичиг баримтыг дугаарласан, хуудас бүрт гарын үсэг зурж байгууллагын тэмдэг дарсан байх 10. Тендерийн баталгаа нь багц тус бүрийн үнийн дүнгийн 1%-аар ирүүлнэ.</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Увс аймаг Зүүнговь сум Засаг даргын тамгын газар</p> <p>Огноо: 2020.04.11</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
<p>ТӨӨЗ 18.1 (б)</p>	<p>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2 жил</p>
<p>ТӨӨЗ 18.1 (г)</p>	<p>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2 жил</p>
<p>ТӨӨЗ 15.9 (б) (1) and (в) (3)</p>	<p>Бараа хүргэгдэх газар: Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны склад</p>

ТӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <ul style="list-style-type: none">• Дотуур байрны хүүхдийн хоолонд шаардагдах махны багц• Дотуур байрны хүүхдийн жимс жимсгэний багц
----------------	--

ГУРАВ:ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1-р багц Дотуур байрны Хүүхдийн хоол хүнсэд шаардагдах мах

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Захиалагч аас авах тоо	Техникийн тодорхойлолт	Нийлүүлэгчийн боломжит нийлүүлэх тоо хэмжээ	Тендерт оролцогчийн үнийн санал	Нийт үнийн санал	Нийлүүлэх хугацаа
1	Хонины мах	Кг	4007	<ul style="list-style-type: none"> • Гарал, үүслийн гэрчилгээтэй байна • Өнгө үзэмж сайтай байх /Зөвхөн мах 1-р зэрэг / • Эрүүл ахуйн шаардлага хангасан байх • Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн байх • Тээвэрлэлт, Хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна. • Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлдэг байх. • Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх 				
2	Үхрийн мах		4007					

2-р багц Дотуур байрны Хүүхдийн хоол хүнсэнд шаардагдах жимс жимсгэнэ

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж		Техникийн тодорхойлолт	Нийлүүлэгчийн боломжит нийлүүлэх тоо хэмжээ	Тендерт оролцогчийн үнийн санал	Нийт үнийн санал	Нийлүүлэх хугацаа
1	Чацарганы шүүс	Л	300	<ul style="list-style-type: none"> • Гарал, үүслийн гэрчилгээтэй байна • Эрүүл ахуйн шаардлага хангасан байх • Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн байх • Тээвэрлэлт, Хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна. • Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлдэг байх. • Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх 				
2	Үхрийн нүдний шүүс	Л	700					
3	Аньсны шүүс	Л	800					
4	Нэрсний шүүс	Л	300					

ТАВ: ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2020.04.30

Ерөнхий боловсролын сургуулийн захирал _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

ТАВ: ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 12. Шалгах болон турших | 12.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 13. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 13.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 14. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 14.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 15. Баталгаат засварын хугацаа | 15.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [<i>моо</i>] жил байна. |
| 16. Гэрээнд өөрчлөлт оруулах | 16.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 17. Төлбөр | 17.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [<i>ГТН-д заасан <i>моо</i></i>] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 18. Бараа нийлүүлэх хуваарь | 18.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 19. Алданги оногдуулах | 19.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 20. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 20.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 21. Маргааныг шийдвэрлэх | 21.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

ЗУРГАА: ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **Ерөнхий боловсролын сургууль** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]